



СУРГУУЛЬ БАЙГУУЛАГДСАН ТҮҮХТ 57 ДАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО

2023-2024 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдаж сургуулийн захирал Д.Буяндэлгэр нээж нийт багш ажилчид, оюутан суралцагчдадаа мэнд дэвшүүллээ.



PEARSON ВТЕС ОЛОН УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБАН ЁСНЫ ТӨВ БОЛЛОО

Pearson ВТЕС хөтөлбөрийн төгсөгчид үндэсний болон олон улсын мэргэжлийн дипломтой төгсөх бөгөөд ажлын байранд шууд гаран ажиллах эсвэл дотоодын болон гадаадын их, дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах боломжтой болох юм.



ЧИГЛҮҮЛЭХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.

2023-2024 оны хичээлийн жилд манай хамт олонтой нэгдэж байгаа шинэ багш нараа хүлээн авч, чиглүүлэх сургалтыг сургалтын албаны зүгээс 6 чиглэлээр зохион явууллаа





НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ

СУРАЛЦАГЧИД "ӨӨРТӨӨ ЗӨВ ДАДАЛ ХЭВШҮҮЛБЭ" УРИАН
ДОР БЯЦХАН CONTENT БЭЛТГЭН ТҮГЭЭЛЭЭ

ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ ДАХИН БАЙГУУЛАВ.

Сувдан тамир электроник ХХК-тай төгсөгчдийг үйлдвэр аж ахуйн нэгж дээр дадлагажуулах ажлын байран дах ур чадварыг сайжруулах, сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах, мэргэжлийн багш нарын ур чадварыг дээшлүүлэхэд ажил олгогчдыг татан оролцуулах ХЗЗ-ийн эрэлт, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэх, харилцан туршлага судлах ажиллагааны хүрээнд хамтран ажиллах гэрээг дахин 1 жилээр сунган хамтран ажиллахаар боллоо




Ахмадын баярын 31 дэх өдрийг тохиолдуулан Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн хамт олон ахмад багш ажилтнаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА.

Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь БНСУ-ын "Korea Sketch Make-up Association"-той багш, суралцагчдад гоо сайхны салбарт гарч буй сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийн арга барил эзэмшүүлэх, сургалт зохион байгуулах олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллах гэрээг байгууллаа



Урлал Дизайны Тэнхимийн ҮНЭТ ЭДЛЭЛ ДАРХАН мэргэжлийн Б. Жамаа багшийн хөдөлмөр алдрыг тэмдэглэх хүндэтгэлийн үйл ажиллагаа боллоо



СУРАЛЦАГЧДЫГ ДЭМЖИХ АЖИЛЛАГАА

ЭЦЭГ ЭХ АСРАН ХАМГААЛАГЧДЫН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ



Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Pearson BTEC international IT level 3 хөтөлбөрийн хүрээнд Мэдээллийн технологийн мэргэжлээр суралцаж байгаа нийт суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагчдын уулзалтыг зохион байгууллаа



НАМРЫН СПАРТАКИАД АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2023 оны 9-р сарын 16-24-ний өдрүүдэд төрөлт тэмцээн явагдаж дүнгээ гаргалаа

Волейболын тэмцээнд эрэгтэй 38 баг эмэгтэй 32 баг нийт 70 анги буухиа тэмцээнд 55 ангийн 220 суралцагч, харайлтын төрөлд эрэгтэй 55 эмэгтэй 34 суралцагч 100м гүйлтийн төрөлд эрэгтэй 54 эмэгтэй 49 суралцагч Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй 44 анги эмэгтэй 28 анги нийт 72 анги Теннисний төрөлд эрэгтэй 28 суралцагч эмэгтэй 26 нийт 54 суралцагч Шатарын төрөлд эрэгтэй 28 эмэгтэй 20 суралцагч нийт 48 суралцагч оролцлоо



МАХАТМА ГАНДИЙН ХӨШӨӨНД ЦЭЦЭГ ӨРГӨЖ, ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦЛОО

Махатма Гандигийн мэндэлсний 153 жилийн ойг тохиолдуулан Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин Сайдын Яамнаас зохион байгуулсан Махатма Гандийн хөшөөнд цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээнд Ражив Гандийн нэрэмжит Политехник Коллежийн захирал Д.Буяндэлгэр, оюутан суралцагч, багш нарын төлөөллийн хамт оролцлоо



ЭЦЭГ ЭХ АСРАН ХАМГААЛАГЧДЫН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАВ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж, БНСУ-ын Кён Ин эмэгтэйчүүдийн их сургууль Сожон Их сургуультай хамтарсан 1+1 тусгай хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын эцэг эхчүүдтэй сургуулийн удирдлага уулзаж ярилцлаа

